БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Өлзийт сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код: БНА-2020/130/СТА-ТШЗ**


Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70444470 Цахим хаяг:

Аудитор: Ж.Байгалмаа

Утас: 89966116 Цахим хаяг: Baigalmaa_bhr88@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

Аудитын гэрчилгээ ..... 3
Аудитын тайлан ..... 4
2.1. Оршил ..... 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 8
2.13. Шилэн дансны мэдээлэл ..... 8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..... 8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 8
Менежментийн захидал ..... 9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 9
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 13

## Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.17 № 1/106

танай ______ -ны № ______ -т

ӨЛЗИЙТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.БАТТУЛГА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Өлзийт сумын цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Өлзийт сумын цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын цэцэрлэгийн оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020062

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

**Аудитын тайлан**
**2.1. Оршил**

Өлзийт сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Б.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

**2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.08-наас 2020.02.11–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Хонгорын үр сад аудит ХХК-ны аудитор Б.Бямбаа хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын Цэцэрлэг 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хонгорын үр сад аудит ХХК-ны газарт 2020.02.10-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Өлзийт сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Залуу багш нарын анхдугаар чуулган”-ны зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, багшийн хөгжлийг дэмжиж, хичээл сургалтын бэлтгэлийг чанартай хийж, хүүхдийн тал бүрийн хөгжлийг хангаж, сургуулийн өмнөх боловсрол олгох.” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Өлзийт сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хамруулан сургах тойргийн хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг өмнөх жилээс 2-3 хувиар ахиулах.
- Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, малчдын хүүхдийн хөгжлийг эцэг эхийн оролцоон дээр түшиглэн хангах ажлыг зохион байгуулна.
- Багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай хийж, ЗАН болон багаараа хамтран нээлттэй, судалгаат, хамтын, зочинтой хичээлүүдийг явуулах
- Багш ажлын байран дээрээ мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх ажлыг хэвшүүлж, багшийн хөгжлийн төвийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах
- Цогц аюулгүй орчин бүрдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах, даван туулах чадварын боловсролыг бусдад олгох гэсэн эрхэм зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Өлзийт сумын цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Өлзий сумын цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolouc программ хангамж ашигладаг байна.

Өлзийт сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Өлзийт сумын цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 358445,9 мянган төгрөгөөс тооцон 7168,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 7168,9 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

**2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Өлзийт сумын цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1098725,6 мянган төгрөгөөр буюу 0,47%-иар хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1169686,2 мянган төгрөгөөр

тус тус өссөн, бараа материалын дансны үлдэгдэл 3286,8 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0,00 | 0,00 | |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 0,00 | 0,00 | 0,00 |
| Бараа материал | 75594,7 | 78881,5 | 3286,8 |
| Үндсэн хөрөнгө | 983796,7 | 2153482,9 | 1169686,2 |
| хуримтлагдсан элэгдэл | -56040,9 | -130288,3 | -74247,3 |
| **Нийт хөрөнгө** | 1003350,5 | 2102076,1 | 1098725,6 |
| Өр төлбөр | 0,00 | 0,00 | 0,00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1003350,5 | 2102076,1 | 1098725,6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1003350,5 | 2102076,1 | 1098725,6 |

Бараа материалын дансны үлдэгдэл 3286,8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалт, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн өмнөх оноос 1169,7 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант онд 1177004,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн энэ нь Шинэ цэцэрлэгийн барилга ашиглалтад орж санхүүгийн тайланд орлого 1159000,0 мянган төгрөгийн , төсвийн хөрөнгөөр 4570,0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсныг орлогод бүрэн тусгасан байна.

Мөн Өлзийт сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.05.21-ны өдрийн 21 тоот тогтоолоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон 7318,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн элэгдэл эхний үлдэгдэл 56040,9 мянган төгрөг тус онд 79166,8 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, оны эцэст 130288,3 мянган төгрөг болжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онд байхгүй, тайлант хугацаанд нэмж өр үүсээгүй, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1169686,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд үр дүнгийн тайлангийн өөрчлөлттэй холбоотой байна.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нийт 282479,6 мянган төгрөгийн зардлын 235073,0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, Орон нутгийн төсвөөс 47406,6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 282390,7 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 88,8 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

**2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1316,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрэв.

Аудитаар дараах 1316,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Халаалтын зардлаас байгууллагын багш, ажилтан нарт даргын 2019.12.26-ны өдрийн А/37 тоот тушаалаар 1316,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт"-ын 210302 кодтой "Түлш, халаалт" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргаж заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

**2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.13. Шилэн дансны мэдээлэл**

Өлзийт сумын цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | | 4 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 93 | 3 | |
| | Нийт | 27 | 151 | 143 | 4 | 4 |

Улирал бүр мэдээлдэг төсвийн гүйцэтгэлийн мэдээний 3 дугаар улирлын мэдээ, тухай бүр мэдээлэх" Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт"-ийн 7 дугаар сарын мэдээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах заасан мэдэгдлийн 8 дугаар сарын мэдээ зэрэг 5 мэдээг санамсаргүй байдлаас хоцроосон байна. Мөн тухай бүр мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний 1,5,7,9 дугаар мэдээг 10 сард нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлаж өөрчлөлт оруулсны улмаас хоцроосон байна.

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Өлзийт сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Өлзийт сумын цэцэрлэгийн2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-1А**

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 75,594,782.40 | 78,881,544.68 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 75,594,782.40 | 78,881,544.68 |
| 351 | Түүхий эд материал | 63,413,932.22 | 64,647,844.50 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 63,413,932.22 | 64,647,844.50 |
| 354 | Хангамжийн материал | 12,180,850.18 | 14,233,700.18 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 481,500.00 | 508,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,488,700.00 | 2,521,750.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 147,000.18 | 663,600.18 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,063,650.00 | 10,540,350.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 927,755,749.93 | 2,023,194,604.82 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 927,755,749.93 | 2,023,194,604.82 |
| 392 | Биет хөрөнгө | 923,005,749.93 | 2,018,444,604.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 896,975,548.00 | 2,055,975,548.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -65,121,025.92 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 24,839,690.00 | 30,974,490.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -18,342,855.92 | -21,011,680.53 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 57,131,503.03 | 61,682,909.74 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,598,135.18 | -44,055,636.47 |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,750,000.00 | 4,750,000.00 |
| 39301 | Програм хангамж | 100,000.00 | 100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -100,000.00 | -100,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,750,000.00 | 4,750,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,003,350,532.33 | 2,102,076,149.50 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,003,350,532.33 | 2,102,076,149.50 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,003,350,532.33 | 2,102,076,149.50 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 70,793,223.00 | 70,793,223.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 70,793,223.00 | 70,793,223.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -2,546,365.54 | 1,096,179,251.63 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -2,546,365.54 | -2,546,365.54 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,098,725,617.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 935,103,674.87 | 935,103,674.87 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,003,350,532.33 | 2,102,076,149.50 |

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 221,814,490.58 | 1,457,171,600.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,490,266.68 | 1,174,690,800.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,490,266.68 | 1,174,690,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,490,266.68 | 1,174,690,800.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,490,266.68 | 1,174,690,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 6,848,223.90 | 47,407,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 206,476,000.00 | 235,073,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,024,061.90 | 1,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,024,061.90 | 1,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 00.00 | 47,406,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 47,406,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 227,953,374.43 | 356,046,783.01 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 227,953,374.43 | 356,046,783.01 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 212,727,445.53 | 355,854,681.01 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 111,683,060.00 | 161,839,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 111,683,060.00 | 161,839,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 13,513,551.00 | 20,971,250.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,084,613.00 | 14,283,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,107,235.00 | 1,679,165.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 885,787.00 | 1,321,745.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 221,447.00 | 326,240.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,214,469.00 | 3,360,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,860,231.00 | 44,363,598.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 735,985.00 | 2,372,118.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,973,246.00 | 40,191,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 151,000.00 | 1,800,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,774,420.19 | 10,447,604.72 |
| 210401 | Бичиг хэрэг | 76,300.00 | 71,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 651,881.19 | 755,859.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 792,439.00 | 1,430,408.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 114,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 253,800.00 | 879,850.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 7,195,987.72 |
| 2105 | Нормативт зардал | 32,326,653.00 | 37,036,383.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,050.00 | 47,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,099,903.00 | 36,898,883.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 187,700.00 | 90,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 63,999.82 | 261,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 63,999.82 | 261,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 42,000.00 | 95,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 42,000.00 | 95,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 629,000.00 | 431,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 629,000.00 | 181,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 250,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,834,530.52 | 80,408,645.29 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 91,000.00 | 1,241,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,238,870.52 | 79,166,845.29 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,225,928.90 | 192,102.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,704,262.00 | 102,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 383,000.00 | 102,100.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,521,666.90 | 1,200.00 |
| 213304 | Хөрөнгийн | 00.00 | 1,200.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 43,402.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 43,402.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 45,400.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 45,400.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -6,138,883.85 | 1,101,124,816.99 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 2,239,801.90 | 2,399,199.82 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,239,801.90 | 2,399,199.82 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | -2,239,801.90 | -2,399,199.82 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -8,378,685.75 | 1,098,725,617.17 |

**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 213,324,223.90 | 282,480,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 213,324,223.90 | 282,480,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 206,476,000.00 | 235,073,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,024,061.90 | 1,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,024,061.90 | 1,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 00.00 | 47,406,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 47,406,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 213,324,223.90 | 282,480,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 213,324,223.90 | 282,480,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 198,098,295.00 | 282,288,698.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 111,670,675.00 | 161,839,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 100,470,835.00 | 133,049,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 4,204,800.00 | 16,146,600.00 |
| 210104 | Урамшуулал | 6,995,040.00 | 12,642,700.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 13,525,936.00 | 20,971,250.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,030,091.00 | 14,283,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,110,258.00 | 1,679,165.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 919,507.00 | 1,321,745.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 212,724.00 | 326,240.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,253,356.00 | 3,360,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,033,301.00 | 44,363,598.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 735,985.00 | 2,372,118.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,123,316.00 | 40,191,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 174,000.00 | 1,800,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,122,850.00 | 9,122,567.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 181,139.00 | 90,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 751,811.00 | 690,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 772,700.00 | 1,430,408.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 41,900.00 | 51,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 179,859.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 375,300.00 | 6,680,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 32,282,423.00 | 37,404,183.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,050.00 | 47,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,868,473.00 | 36,898,883.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 374,900.00 | 457,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 127,000.00 | 6,656,200.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 127,000.00 | 3,156,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 42,000.00 | 95,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 42,000.00 | 95,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 629,000.00 | 481,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 629,000.00 | 231,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 250,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,665,110.00 | 1,355,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 231,000.00 | 1,355,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,225,928.90 | 192,102.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,704,262.00 | 102,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 383,000.00 | 102,100.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,521,666.90 | 1,200.00 |
| 213304 | Хөрөнгийн | 00.00 | 1,200.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 43,402.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 43,402.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 45,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 45,400.00 |

**СТ-2А**

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-4А**

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 70,793,223.00 | 935,103,674.87 | -2,546,365.54 | 00.00 | 1,003,350,532.33 |
| D01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 70,793,223.00 | 935,103,674.87 | -2,546,365.54 | 00.00 | 1,003,350,532.33 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 70,793,223.00 | 935,103,674.87 | -2,546,365.54 | 00.00 | 1,003,350,532.33 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,098,725,617.17 | 00.00 | 1,098,725,617.17 |
| D09 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 70,793,223.00 | 935,103,674.87 | 1,096,179,251.63 | 00.00 | 2,102,076,149.50 |

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 194,919,600.00 | 157,016,467.00 | 282,479,600.00 | 282,390,798.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 194,919,600.00 | 157,016,467.00 | 282,479,600.00 | 282,390,798.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 194,816,000.00 | 156,913,467.00 | 282,377,500.00 | 282,288,698.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 121,665,700.00 | 94,374,863.00 | 161,839,000.00 | 161,839,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 110,370,500.00 | 81,213,612.00 | 133,049,700.00 | 133,049,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 5,012,300.00 | 7,260,948.00 | 16,146,600.00 | 16,146,600.00 |
| 210104 | Урамшуулал | 6,282,900.00 | 5,900,303.00 | 12,642,700.00 | 12,642,700.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 13,383,200.00 | 10,458,311.00 | 21,004,800.00 | 20,971,250.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,516,600.00 | 8,382,170.00 | 14,283,200.00 | 14,283,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 973,400.00 | 209,979.00 | 1,680,400.00 | 1,679,165.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,216,600.00 | 570,100.00 | 1,344,300.00 | 1,321,745.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 243,300.00 | 106,949.00 | 336,000.00 | 326,240.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,433,300.00 | 1,189,113.00 | 3,360,900.00 | 3,360,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,272,400.00 | 16,371,535.00 | 44,406,600.00 | 44,363,598.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 697,300.00 | 701,621.00 | 2,379,900.00 | 2,372,118.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,271,100.00 | 15,380,456.00 | 40,226,700.00 | 40,191,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 304,000.00 | 289,458.00 | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 579,500.00 | 688,220.00 | 9,125,500.00 | 9,122,567.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 70,100.00 | 59,600.00 | 91,900.00 | 90,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 308,000.00 | 390,560.00 | 690,000.00 | 690,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 67,400.00 | 65,860.00 | 1,431,700.00 | 1,430,408.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 42,300.00 | 49,600.00 | 51,100.00 | 51,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 180,000.00 | 179,859.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 91,700.00 | 122,600.00 | 6,680,800.00 | 6,680,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 41,219,700.00 | 33,552,338.00 | 37,412,900.00 | 37,404,183.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,000.00 | 59,380.00 | 47,700.00 | 47,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,790,000.00 | 33,143,258.00 | 36,907,400.00 | 36,898,883.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 396,700.00 | 349,700.00 | 457,800.00 | 457,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 69,200.00 | 93,600.00 | 6,656,600.00 | 6,656,200.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 69,200.00 | 93,600.00 | 3,156,600.00 | 3,156,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 101,900.00 | 64,000.00 | 95,300.00 | 95,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 101,900.00 | 64,000.00 | 95,300.00 | 95,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 277,800.00 | 301,200.00 | 481,500.00 | 481,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 277,800.00 | 301,200.00 | 231,500.00 | 231,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 250,000.00 | 250,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1246600.00 | 1009400.00 | 1355300.00 | 1355300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 | 1,355,300.00 | 1,355,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 103600.00 | 103000.00 | 102100.00 | 102100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 103,600.00 | 103,000.00 | 102,100.00 | 102,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 103,600.00 | 103,000.00 | 102,100.00 | 102,100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 195,369,700.00 | 157,016,467.00 | 282,479,600.00 | 282,390,798.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 195,369,700.00 | 157,016,467.00 | 235,073,000.00 | 234,984,198.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 00.00 | 235,073,000.00 | 234,984,198.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 00.00 | 00.00 | 47,406,600.00 | 47,406,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 47,406,600.00 | 47,406,600.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 00.00 | 00.00 | 13.00 | 13.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 00.00 | 00.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 00.00 | 00.00 | 03.00 | 03.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | 00.00 | 09.00 | 09.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:АУДИТОР Б.БЯМБАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ